

ЭРДЭНЭТ АВТО ЗАМ ХК  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Эрдэнэт авто зам хк нь зам барилга угсралтын чиглэлээр Улаанбаатар хот болон хөдөө орон нутгуудад зам барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж өмнөх он жилүүдэд Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтаар болон Олон улсын зээл тусламжын хүрээнд хэрэгжсэн гудамж төсөл, хувийн хөрөнгө оруулалттай компаниудад зам барилгын ажлуудыг гүйцэтгэж 1981 оноос тасралтгүй 40 гаруй жил үйл ажиллагаа явуулж, олон арван зам гүүрийг чанарын өндөр үзүүлэлттэй ашиглалтанд хүлээлгэн өгч, үйл ажиллагаа явуулж ирсэн.

Компани нь 2021 онд төлөвлөгөө зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллахад улс орны нийгэм эдийн засгийн хямрал, зах зээлийн онцлог, цар тахлын хөл хориотой сүүлийн 3 жил төлөвлөгөө зорилтоо ханган биелүүлэхэд хүндрэл учирч хөрөнгө оруулалтын эх үүсвэргүйгээс шалтгаалж бүрэн дуусгах боломжгүй байна.

Ийм учраас 2021 онд борлуулалтын төлөвлөгөө тасарч, ашиг орлого муутай ажилласан. Энэ нь компанийн үйл ажиллагаанаас бус зах зээлийн хүндрэлээс шалтгаалан үйл ажиллагаа явуулаагүй болно.

Цаашид 2022 онд хийгдэхээр хүлээгдэж байгаа ажил болон шинээр эхлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд компанийн инженер техникийн ажилчид болон нийгмийн хариуцлагын өмнө хүлээсэн үүргээ ханган биелүүлэхийн тулд бид анхаарч ажилах шаардлагыг хүлээн ажиллаж байна.

2022 онд төлөвлөгөөнд тусгагдсан ажлын санхүүжилт болон хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн санхүүжилтыг бүрэн гүйцэт оруулахад манай үйл ажиллагаа жигдэрч ашигтай ажиллах боломжийг бүрдүүлж байгаа юм.

Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхэд салбар яам, бусад газруудын дэмжлэг туслалцаа , хамтын ажиллагаа шаардлагатай байгааг анхаарч үзнэ үү.

Зам барилгын ажил нь улирлын чанартай учраас тогтмол үйл ажиллагаа явуулахад хүндрэл их бөгөөд үйл ажиллагааны хямралаас гарахад норм норматив, үнэ тариф, өртөгт нөлөөлж байгаа олон хүчин зүйлүүдийг шийдвэрлэхэд зорилт тавин ажиллаж байна.

ЭРДЭНЭТ АВТО ЗАМ ХК

